



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/Ч/19

Арвайхээр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажлын удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулан, шалгалтын дүнг танилцуулж, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0819

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар  
сарын 06 өдрийн 0119 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

**АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХАМТАРСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүдэд:

Г.Баясгалан (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Т.Очирсүрэн (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Геологи уул уурхайн хяналтын улсын байцаагч)

Б.Батзул (аймгийн Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан Эрүүгийн ахлах мөрдөгч, Цагдаагийн хошууч)

Ш.Мөнхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн ажилтан)

Сумдын Засаг дарга, Экологийн цагдаа, Байгаль орчны байцаагч, Байгаль хамгаалагч нар

-оОо-

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар  
сарын 26 өдрийн 1149 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт

**АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХАМТАРСАН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

**Нэг. Шалгалтын зорилго**

Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлолт явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоомжийг шалгаж, “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний төлөвлөгөө болон хуулийн хэрэгжилтийг хангуулахад оршино.

**Хоёр. Шалгалтад хамрагдах иргэн, аж ахуйн нэгжүүд**

Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд

**Гурав. Шалгалт хийх хугацаа**

Шалгалтыг 2023 оны 06 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд хийж гүйцэтгэнэ.

**Дөрөв. Хяналт, шалгалтаар хийж гүйцэтгэх ажлын чиглэл**

- Байгаль орчныг хамгаалах тухай, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх ашиглахыг хориглох тухай, Ашигт малтмалын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт;

- Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулсан байдал, түүний хэрэгжилт.

- Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай нийгмийн хариуцлагын гэрээний биелэлт.

- Усны ашиглалтын байдал;

- Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх чиглэлээр хийж, гүйцэтгэсэн ажлыг газар дээр нь үзэж танилцах, заавар зөвлөмж өгөх;

- “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хэрэгжилт.

**Тав. Шалгалтын үр дүнг тооцох**

- Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, шаардлагатай бол дүгнэлт, албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгөх;

-

- Шалгалтад хамрагдсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд холбогдох хууль тогтоомж, стандарт, тушаал шийдвэрийг танилцуулах;

- Шалгалтын дүнг холбогдох албан тушаалтанд танилцуулах.